



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар A/214

Өмнөдэлгэр сум


**Сумын Онцгой комиссын
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж,
журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, 59.1.21 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1, 23.3 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өмнөдэлгэр сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Онцгой комиссын “Ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулж, хяналт тавих арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн Онцгой комиссын ажиллах журмыг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг даргын орлогчид даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн A/53 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.




Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj

2324100448

сумын Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 15-ны өдрийн
А/214 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Сумын Онцгой комиссын
бүрэлдэхүүн

Дарга: Сумын Засаг дарга
Орлогч дарга: Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Гишүүд: Засаг даргын орлогч
Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
Ерөнхий боловсролын сургуулийн захирал
Цэцэрлэгийн эрхлэгч
Санхүү албаны дарга
Цаг уурын өртөөний дарга
Соёлын төвийн дарга
Ойн ангийн дарга
1-р багийн Засаг дарга
2-р багийн Засаг дарга
3-р багийн Засаг дарга
4-р багийн Засаг дарга
5-р багийн Засаг дарга
6-р багийн Засаг дарга
Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч
Хөдөө аж ахуйн тасгийн дарга
“Юмт гэгээ” мал эмнэлэг
“Хичээнгүй экспресс” мал эмнэлэг
“НИК” шатахуун түгээх станц
“Жаст ойл” шатахуун түгээх станц
“Буян-Ундрах” шатахуун түгээх станц
Эрчим хүчний деспитчер
Хэсгийн төлөөлөгч

А/214
Сумын Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 15-ны өдрийн
дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Сумын Онцгой комисс (цаашид комисс гэх)-нь өөрийн харьяа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хуулинд заасан аюулт үзэгдэл, техникийн холбоотой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн аюулаас хүн ам, мал амьтан хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хүн хүч, техник хэрэгсэл, материаллаг нөөцийг зохих хууль тогтоомжийн дагуу дайчлан гаргах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хяналт тавихад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага:

23.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

23.2.Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд, орон нутгийн зөвлөлийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүлнэ.

23.3.Улсын Онцгой комиссыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга тэргүүлнэ.

23.4.Улсын онцгой комиссын орлогч дарга нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн онцгой комиссын орлогч дарга нь орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга, сумын онцгой комиссын орлогч дарга нь тухайн сумын Засаг даргын Тамгын газрын дарга байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл

24.1.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа болон цэргийн жинхэнэ алба хаасан иргэн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хуулийн этгээд, эрэлч нохой, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, түүний объект, барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бараа материал байна.

24.2.Мэргэжлийн ангийг Монгол Улсын харьяат, хөдөлмөрийн чадвартай, 18-60 хүртэлх насны эрэгтэй, 18-55 хүртэлх насны эмэгтэй иргэнээр бүрдүүлэх бөгөөд цэргийн жинхэнэ алба хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэй, өрх толгойлсон эх /эцэг/ хамаарахгүй.

24.3.Монголын улаан загалмай нийгэмлэг нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт хүч болон ажиллана.

1.2.Комисс нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

1.3.Сумын Онцгой комиссыг сумын Засаг дарга тэргүүлнэ.

1.4.Комиссын гишүүд ажлын цагаар 30 минут, ажлын бус цагаар 1 цагийн дотор заасан газарт цугларах бөгөөд Онцгой комиссын нарийн бичгийн дарга нь хурлын бэлтгэл ажлыг хангуулан ирцийг бүртгэн хурлын дэг журмыг сахиулна.

1.5.Комиссын хуралд оролцож байгаа гишүүд 60-аас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж тэмдэглэл гаргана.

1.6.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний цар хүрээнээс хамаарч голлон үүрэг гүйцэтгэх байгууллагын гишүүдийг оролцуулан /цомхотгосон хэлбэрээр/ комиссын хурлыг зохион байгуулж болно.

1.7.Онцгой комиссын дарга нь холбогдох хууль тогтоомжоор олгогдсон үүрэг, зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргана.

1.8.Онцгой комисс нь хууль тогтоомж, энэ журмаар олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хурлаараа хэлэлцэж олгогдсон эрхийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар тогтоол, албан даалгавар, захирамж, хурлын тэмдэглэл гаргана.

1.9.Онцгой комиссын гишүүд нь албан үүрэг гүйцэтгэх үедээ Онцгой комиссын даргын гарын үсэг, тэмдэгтэй үнэмлэх ашиглах бөгөөд жигд хувцастай байна.

1.10.Сумын хэмжээнд гарсан гамшиг, аюулт үзэгдлийн төрлөөс хамаарч харъяалах мэргэжлийн байгууллага урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой авах арга хэмжээний санал “Шийдвэрийн төсөл”-ийг боловсруулан комиссын хуралд оруулан шийдвэрийг гаргуулна.

1.11.Онцгой комиссоос гаргасан шийдвэрийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

1.12.Онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Онцгой байдлын хэлтэс, Засаг даргын Тамгын газар эрхэлнэ.


Хоёр. Комиссын үүрэг, эрх

2.1.Комиссын үүрэг

2.1.1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний биелэлтийг хангуулах ажлыг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комисс, Аймгийн онцгой комиссын нэгдсэн шуурхай штабаас энэ чиглэлээр тусгайлан өгсөн үүргийг хэрэгжүүлэх.

2.1.2.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах:

2.1.3.Гамшгийн цагийн байдалд өгсөн дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухайн аж ахуйн нэгж, байгууллагын илтгэл мэдээллийг хэлэлцэж шийдвэр гаргах:



2.1.4.Гамшиг бүхий нутаг дэвсгэр, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, гамшгийн үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас дайчлан гаргасан эд хөрөнгийн нөхөн төлбөрийн асуудлаар мэргэжлийн байгууллагын гаргасан тооцоог үндэслэн санал боловсруулж Аймгийн онцгой комисст хүргүүлэн шийдвэрлүүлэх:

2.1.5.Гамшгийн цагийн байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллага, шинжээчдээр хийлгэх, бий болсон нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиас ирсэн мэдээллийг нэгтгэн дүгнэж, эрх бүхий байгууллага болон холбогдох албан тушаалтанд танилцуулж тэдгээрийг бодит мэдээллээр хангах:

2.1.6.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг орон нутгийн төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж зохицуулах, шаардлагатай нэмэгдэл хүн хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах санал боловсруулан зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх:

2.1.7.Онцгой комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх:

2.1.8.Гамшиг тохиолдсон үед хохирлыг үнэлэх ажлын хэсгийг зохих мэргэжлийн байгууллагын бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулж дүгнэлт гаргуулах:

2.1.9.Зохион байгуулалтын бүтцийн багууд жилийн эцэст сумын Онцгой комисст тайлан гаргах:

2.2.Комиссын эрх.

2.2.1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар сумын удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих:

2.2.2.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах:

2.2.3.Холбогдох байгууллага албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, мэдээлэл, илтгэлийг хэлэлцэж шийдвэр гарган биелүүлэхийг шаардах:

2.2.4.Гамшгийн голомтонд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах:

2.2.5.Гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд орон нутгийн уул уурхайн байгууллагуудын бие бүрэлдэхүүн, тусгай зориулалтын техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дайчлан ажиллуулах:

2.2.6.Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардагдах нэмэлт зардал болон бараа материал, тоног төхөөрөмж гаргах,

яаралтай авах арга хэмжээний талаархи саналыг нэн даруй Аймгийн онцгой комисст уламжлан шийдвэрлүүлэх:

2.2.7.Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийхдээ хэвлэл, мэдээллийн хэрэгслийг холбогдох журмын дагуу оролцуулах:

2.2.8.Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардагдах нэмэлт зардал болон бараа материал, тоног төхөөрөмж гаргах, яаралтай авах арга хэмжээний талаархи асуудлын саналыг нэн даруй гаргаж Аймгийн онцгой комисст хүргүүлэн шийдвэрлүүлэх:

2.3. Комиссын гишүүний үүрэг:

2.3.1.Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах, гамшгийн голомт буюу хорио цээрийн дэглэм тогтоосон газарт зохих журмын дагуу нэвтэрч үйл ажиллагааг нь шалгаж, заавар зөвлөгөө өгөх:

2.3.2.Гамшгаас хамгаалах хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам Аймгийн онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хянаж шалгах.

2.4. Комиссын гишүүний эрх:

2.4.1.Сумын гамшгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зайлшгүй сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, эрхлэх асуудлын хүрээнд комиссын хуралд асуудал танилцуулж, авах арга хэмжээний талаар санал оруулж шийдвэрлүүлэх;

2.4.2.Гамшгаас хамгаалах хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан дүрэм журам, Онцгой комиссын шийдвэр, албан даалгаврыг хэрэгжүүлэх асуудлаар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэх,

Гурав. Сумын онцгой комиссын удирдлага зохион байгуулалт:


3.1.Аймгийн онцгой комиссоос баталсан үлгэрчилсэн журмыг үндэслэн сумын Онцгой комиссын ажиллах журмыг сумын Засаг дарга батална.

3.2.Сумын Онцгой комиссын дарга нь Засаг дарга, комиссын орлогч дарга нь Засаг даргын Тамгын дарга, нарийн бичгийн дарга нь Байгаль орчны хяналтын улсын байцаагч байна.

3.3.Сумын Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх, аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй ажиллана.

3.4.Сумын онцгой комисс нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

(27¹.3.Онцгой комиссын шийдвэр, тогтоосон хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг сахин мөрдөхийг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, иргэнээс шаардана.



27¹.4.Шуурхай штаб, шуурхай бүлгийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын, орон нутагт Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлнэ.

27¹.5.Улсын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.)

3.5.Сумын онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан ажил, үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний болон зардлын тайланг гамшгийн нөхцөл байдал дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор, ерөнхий үйл ажиллагааны тайланг жилийн эцэст аймгийн Онцгой комисст тайлагнана.

Дөрөв. Комиссын зардал

4.1.Сумын нутаг дэвсгэрт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг гамшгийн эрсдлийн сан болон сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэнэ.

4.2.Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс давсан хохирол учирсан, эсхүл хуульд заасан тохиолдолд гамшгаас хамгаалах зардлыг холбогдох төсөв, тооцооны хамт аймгийн Онцгой комисст хандан шийдвэрлүүлнэ.

4.3.Сум нь гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна.

Тав. Хариуцлага

5.1.Онцгой комиссын гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хурал тасалбал Онцгой комиссын даргын шийдвэрээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцно.

5.2.Онцгой комиссын гишүүн нь албан үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1.Онцгой Комисс нь гамшгийн үед зохион байгуулсан ажил, үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний болон зардлын тайланг гамшгийн нөхцөл байдал дууссаны дараа аймгийн Онцгой комисст хандан шийдвэрлүүлнэ.

6.2.Онцгой Комисс нь гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр зохион байгуулсан ажлын тайлангаа жил бүрийн 12 дугаар сард Аймгийн онцгой комисст тайлагнана.

6.3.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.

